

БАТЛАВ  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТӨР ОРОЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Д.ЗАГДЖАВ

“УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН  
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” СЭДЭВТ АУДИТАД ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ,  
ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 05 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар ҮАГ/АД - 2024 - 18 Улаанбаатар хот

**АЖЛЫН ЗОРИЛГО:** “Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологийн судалгааны ажлын хэрэгжилт, үр дүн”-д хийх гүйцэтгэлийн аудитын хүрээнд 2018-2023 онд улсын төсвийн хөрөнгөөр хийсэн геологийн судалгааны ажлын үр өгөөжийг тооцох, хэрэгжилтийг үнэлэх, судалгаа хийж санал зөвлөмж боловсруулахад энэхүү ажлын зорилго оршино.

### АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

**Эхлэх хугацаа:** 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдөр

**Дуусах хугацаа:** 2024 оны 10 дугаар сарын 18-ний өдөр

**Байршил:** Улаанбаатар хот

### НЭГ. ҮНДЭСЛЭЛ

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, МУЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийнэ.

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 “Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/82 дугаар тушаалаар баталсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-д заасны дагуу Геологийн судалгааны ажлын туршлагатай, тус чиглэлийн нарийн мэргэжлээр мэргэшсэн хүний нөөц бүхий шинжээчийн баг, хуулийн этгээдийг аудитад шинжээчээр ажиллуулах шаардлага үүссэн.

Төрийн аудитын үйл ажиллагаанд салбарын мэргэжлийн баг, судлаач шинжээчдийг татан оролцуулж аудитын санал, дүгнэлтийг судалгааны мэдээлэл дүгнэлтээр нотлох баримтаар баяжуулж, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж боловсруулах шаардлагатай гэсэн бодлогыг төрийн аудитын байгууллага баримталж байна.

### ХОЁР. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Шинжээч нь 2018-2023 оны Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологийн судалгааны ажлын үр өгөөжийг тооцох, хэрэгжилтийг үнэлэх, судалгаа хийж санал зөвлөмж боловсруулж, хариуцан хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд болон гүйцэтгэгч байгууллагуудын үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэнэ.

### ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Шинжээч нь дараах ажилбаруудыг хэрэгжүүлж, аудитын гүйцэтгэлийн үе шат болон тайлагналын үе шатанд шаардлагатай мэргэжлийн санал, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулна. Үүнд:

Д/д	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Зорилго	Шалгуур үзүүлэлт
1	Аудитын багийн гишүүдэд арга зүйн зөвлөмж өгөх,	Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 "Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/82 дугаар тушаалаар баталсан "Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам"-д заасны дагуу "Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологийн судалгааны ажлын үр дүнгүйг хэрэгжилт, үр дүн"-д хийх гүйцэтгэлийн аудитад нарийн мэргэжлийн санал, дүгнэлт гаргах шаардлага үүссэн.	"Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геологийн судалгааны ажлын хэрэгжилт, үр дүн"-д хийх гүйцэтгэлийн аудитын хүрээнд Улсын төсвийн хөрөнгөөр 2018-2023 онд хэрэгжүүлсэн геологийн судалгааны ажилд зарцуулсан хөрөнгийг үр дүнтэй зарцуулж байгаа эсэх, төсөл хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн эсэх, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх	Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Уул уурхайн сайдын 2015 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 108 дугаар тушаалаар баталсан Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам,
2	Улсын төсвийн хөрөнгөөр 2018-2023 онд хэрэгжүүлсэн геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайланд дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах. Үүнд: • 1:50000 масштабын 10 төсөл • Сэдэвчилсэн 6 төсөл	Улсын төсвийн хөрөнгөөр 2018-2023 онд хэрэгжүүлсэн геологийн судалгааны ажлын үр нөлөө, үр өгөөжийг тооцож, цаашид геологийн судалгааны ажлыг эрчимжүүлэх, эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөөтэй дүгнэлт гаргаж, бодлогын санал зөвлөмж боловсруулах		
3	<b>Нэмэлт шаардлага:</b> Тухайн ажил, үүргийн хүрээнд нэмэлт ажил хийгдэх тохиолдолд гүйцэтгэх, ажил үүрэг бүрд нэмэлт ажил оруулах боломжтой.			

Шинжээчийн ажлын тайлангууд нь хавсралтууд орохгүйгээр 30-аас багагүй 80-аас ихгүй хуудас /мөр хоорондын зай "single" үсгийн хэмжээ arial 12/ байх бөгөөд гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан, хавсралтуудтай байна.

### ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Шинжээч нь ажлын даалгаварт тусгасан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, ажлын үр дүнг илтгэсэн шинжээчийн тайлан бичнэ.

Гүйцэтгэх ажлын дэд сэдэв тус бүрээр тайлан гаргана.

Шинжээчийн тайланд судалгааны явцад илэрсэн алдаа, зөрчил, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн шинжилгээний үр дүнгээс гадна цаашид анхаарах асуудал, авах арга хэмжээний талаар зөвлөмж, саналыг боловсруулж тусгана.

Шинжээчийн тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох зүйлс, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

### ТАВ. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Шинжээч нь тухайн аудитад оролцоход ашиг сонирхлын зөрчилгүй хувь хүн, хуулийн этгээд, байгууллага /түншлэлээр/ байх бөгөөд албаны болон төрийн нууцыг задруулахгүй гэдгээ бүрэн илэрхийлж, Үндэсний аудитын газартай нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Шинжээчийн дүгнэлт гаргах шинжээчийн баг, хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Хуулийн этгээдийн хувьд:

- Геологийн судалгааны чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;

Ажиллах хүчний шаардлага:

- Хуулийн этгээд нь 5-аас доошгүй мэргэшсэн ажилтантай байх;
- Гурваас доошгүй зөвлөх инженертэй байх;
- Аудитад шинжээчээр ажиллах ажилтнууд нь Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн геологийн судалгааны ажилтай ямар нэгэн ашиг сонирхлын зөрчилгүй байх;

Багийн хувьд:

- Багийн ахлагч нь тухайн гүйцэтгэх ажлын чиглэлээр зөвлөх инженерийн зэрэгтэй, 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай байх;
- Баг нь 5-аас доошгүй гишүүнтэй байх;
- Багийн гишүүдийн 3-аас доошгүй гишүүн нь зөвлөх зэрэгтэй байх;
- Багийн гишүүд нь тухайн гүйцэтгэх ажлын хүрээнд 3-аас доошгүй жилийн туршлагатай байх;
- Багийн гишүүд нь Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн геологийн судалгааны ажилтай ямар нэгэн ашиг сонирхлын зөрчилгүй байх;

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

**Бүрдүүлэх материал:**

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, боловсролын зэргийн диплом, бусад үнэмлэх сертификатын хуулбар;
- Ажлын туршлага тодорхойлсон дэлгэрэнгүй намтар /багийн гишүүн тус бүрээр/;
- Ажлын туршлагыг нотлох хийсэн ажлын гэрээ, тайлан, акт;
- Хуулийн этгээдийн хувьд татвар, нийгмийн даатгалын лавлагаа, сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан;
- Шинжээчээр ажиллах ажилтнуудын нийгмийн даатгалын лавлагаа;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугтуйлсан байх).

Дээрх шаардлагыг хангасан тухай нотлох баримтын баталгаажсан хуулбар ирүүлж, цуглуулсан бүх баримт, мэдээлэл, зөвлөмжийг хавсаргана.

**ЗУРГАА. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан санхүүжүүлэгч гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Гэрээт ажлын санхүүжилтийг гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу олгоно.


**Хянасан:**

ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

**Боловсруулсан:**

АУДИТОР



Д.ЭНХБОЛД

М.НАРАНЖАРГАЛ

М.БАЯРТОГТОХ